



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@mecs.gov.mn
Вэб сайт: meds.gov.mn

2023.06.29 № 2/3090
танай _____-ны № _____-т

Тайлан хүрүүлэх тухай

Танд Монгол улс, Европын Холбоо хоорондын “Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлд зориулсан төсвийн дэмжлэг” санхүүгийн хэлэлцээр (АСА/2019/42287)-ийн нэмэлт гэрээний 4 дүгээр шалгуур үзүүлэлт дэх “МСҮТ-ийн суралцагчид болон эдгээр төвүүдийн талаарх салбарын хэмжээний чанарын үнэлгээ”-ний тайланг хүргүүлж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/56 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, аргачлал”-ын дагуу 2023 оны 3 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд туршилтын чанарын үнэлгээг улсын хэмжээнд зохион байгуулсан.

2022-2023 оны хичээлийн жилд нийт 77 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 69 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж туршилтын чанарын үнэлгээнд хамрагдсан.

Үүнээс санхүүжилтийн хэлэлцээр дэх 4 дүгээр шалгуур үзүүлэлтийн дагуу Улаанбаатар хотод сургалтын үйл ажиллагаа явуулж буй 15 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон Политехник коллежийн чанарын үнэлгээний дүнг урьдчилсан байдлаар Боловсролын үнэлгээний төвөөс ирүүлснийг хавсралтаар хүргүүлээ.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН



14239 3169

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН
БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ - 2023**

Улаанбаатар хот

АГУУЛГА

НЭГ. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ	3
1.1 Үндэслэл	3
1.2 Зорилго, зорилт	4
1.3 Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын чанарын үнэлгээний менежмент, зохион байгуулалт	5
1.4 Судалгааны арга зүй, аргачлал	11
ХОЁР. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ҮР ДҮН	12
2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдаас авсан шалгалтын ерөнхий үр дүн	12
2.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах ажилтнаас авсан шалгалтын ерөнхий үр дүн	16
2.3 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нараас авсан шалгалтын ерөнхий үр дүн	19
ГУРАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	22

НЭГ. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

1.1 Үндэслэл

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино” хэмээн тодорхойлсон бол олон улсад “Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалт”-ыг “Өргөн хүрээний мэргэжил, үйлдвэрлэл, үйлчилгээ, амьдрах чадвартай холбоотой боловсрол, сургалт, ур чадварыг хөгжүүлэх” хэмээн тодорхойлж байна¹.

Мэргэжлийн боловсрол сургалт нь насан туршийн боловсролын нэг хэсэг болох дунд, дээд боловсролын түвшинд явагдах боломжтой бөгөөд ажлын талбарт суурилан суралцах, тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлдэг.

2021 онд хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгааны зарим үр дүнг авч үзвэл:

- хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны ажлын байрны захиалга 87.0 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 57.9 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын ажлын байрны захиалга 36.0 хувиар өссөн бөгөөд техникийн салбарын хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр хувийг эзэлж байна.

- Ажил мэргэжлийн ангиллын хувьд “Энгийн ажил мэргэжил”, “Мэргэжилтэн”, “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан”, “Худалдаа, үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн нийт захиалгын 68.3 хувийг эзэлж байгааг мөн дурдсан байна.²

- “хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролын ажил мэргэжлийн эрэлтээс илүү мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэгддэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байх хандлага хадгалагдсаар байна. Тодруулбал: тогооч, зөөгч, жолооч, гагнуурчин, цахилгаанчин гэх зэрэг ажил мэргэжлийн эрэлт жил бүрийн эрэлттэй ажил мэргэжлийн ангилалд тогтмол нэрлэгдсээр байна” гэдгийг онцолж тэмдэглэсэн байна.

Ажил олгогчид ажил хайгчийн мэргэжлийн нарийн ур чадвар гэхээс илүүтэй хувь хүний зөөлөн ур чадварыг хамгийн чухал үзүүлэлт гэж үздэг хандлага хэвээр төдийгүй би даан ажиллах чадвар, найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай байдал, харилцааны ур чадвар, цаг ашиглах чадварыг хамгийн ихээр чухалчилж үзсэн байна. Харин мэргэжлийн хувьд төдийлөн өндөр шаардлага тавихгүй ч ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, ёс зүйтэй байх, шинэ санаа гаргах чадварыг илүүд үзэж

¹ ЮНЕСКО (GC) 2015. НҮБ

² Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, 2021

боловсролын түвшний хувьд тодорхой хэмжээний боловсрол эзэмшсэн байх шаардлагыг тавих хандлага нэмэгдэж байна.

2022 оны байдлаар улсын хэмжээнд мэргэжлийн болон техникийн боловсрол олгодог 79 сургалтын байгууллагад нийт 38,034 суралцагч 190 орчим мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байна. Эдгээр сургалтын байгууллагын суралцагчдад мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлж хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчдын эрэлтэд нийцсэн хандлага, ёс зүйтэй ажилтан бэлтгэх үйл ажиллагааны чанарыг тодорхой давтамжтайгаар үнэлэх, үнэлгээний үр дүнд үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага байгааг дээр дурдсан судалгааны дүн харуулж байна.

Боловсролын хөгжлийн чиг хандлага хүртээмжээс чанарт, мэдлэг хүлээн авагч, дамжуулагчаас мэдлэг бүтээгч, мэдлэгийг шүүн тунгаадаг хэрэглэгч, чадамж, чадавхыг хөгжүүлэгчийг бэлтгэх чиглэлээр өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл багш төвтэй сурган заах арга зүйгээс суралцагч төвтэй арга зүйд шилжиж эхлээд байна. Ингэхдээ зөвхөн аль нэг талыг бус “оролт, үйл явц, гаралт”-ын түвшинд бүхэлд нь хэмжих, түүний үр нөлөөг судалдаг болж өөрчлөгдөж байна. Иймээс улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, сургалтын орчин болон хүний нөөцийн чадавх, мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнг үнэлэх үнэлгээг бүхэлд нь хамруулсан судалгааг зохион байгуулж суурь мэдээллийн сан үүсгэх шаардлага бий болж байна.

1.2 Зорилго, зорилт

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байрны шаардлагад нийцсэн чадамж эзэмшиж байгаа эсэхийг нийтлэг мэргэжлийн сургалтын /чадамжийн/ хөтөлбөр, багшийн чадамж, сургалтын орчин, сургалтын чанарт үнэлгээ хийх замаар тодорхойлох, үр дүнд тулгуурлан бодлогын зөвлөмж боловсруулахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг биелүүлэхэд анхаарч ажилласан. Үүнд:

1. Мэргэжлийн болон техникийн боловсролын чанарыг үнэлэх арга зүйн хүрээ, дизайныг боловсруулах;
2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хүний нөөц /удирдлага, багш/-ийн чадамжийг үнэлэх арга хэрэгслийг боловсруулж, үнэлгээ, дүгнэлт хийх;
3. Сургалтын байгууллагын орчин, хүртээмж, холбогдох стандартын хэрэгжилт, дадлагын орчин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц, эдгээрийн ашиглалтын талаарх судалгааны маягт боловсруулан мэдээлэл цуглуулж дүгнэлт гаргах;
4. Чадамжид суурилсан хичээл, сургалтын үйл ажиллагааны бэлтгэл, явц, суралцагчийн эзэмшиж буй чадамжийн түвшнийг үнэлэх шалгалтын материал боловсруулах, үр дүнг үнэлж дүгнэлт гаргах;
5. Суралцагч, төгсөгчид болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа хийж дүгнэлт гаргах;

1.3 Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын чанарын үнэлгээний менежмент, зохион байгуулалт

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээг дараах үндсэн үе шатаар төлөвлөн зохион байгууллаа. Үүнд: (Зураг 1)

Зураг 1. Чанарын үнэлгээ зохион байгуулах менежментийн үе шатууд




1. Бэлтгэл хангах үе шат нь хэд хэдэн үйл ажиллагааг багтааж байгаа бөгөөд түүнийг нэгтгэн зургаар харууллаа.

Зураг 2. Бэлтгэл хангах үе шатанд хийгддэг үндсэн үйл ажиллагаа



- 1.1 Мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд Боловсролын ерөнхий газарт үүссэн дата мэдээлэлд суурилан дараах процессын дагуу мэдээллийг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг хийсэн.

Зураг . Мэдээллийн сан бүрдүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааны зураглал



Хэдийгээр дээрх процессын дагуу мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баталгаажуулах ажлыг хийсэн боловч сургалтын байгууллагын хайхрамжгүй байдлаас шалтгаалан бүрдэл дутуу байх, буруу мэдээлэл илгээх зэрэг асуудал үүсэж байсан.

- 1.2 Үнэлгээний арга хэрэгсэл боловсруулах үйл ажиллагааг 2 ангилсан бөгөөд нэгдүгээрт суралцагч, багш, удирдах ажилтнаас авах бичгийн шалгалтын материал боловсруулах, хоёрдугаарт асуулга судалгаа, хяналтын хуудас боловсруулах гэсэн чиглэлээр баг бүрдүүлэн ажилласан.

Бичгийн болон ур чадварын шалгалтын материал боловсруулах

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багшаас авах бичгийн шалгалтын агуулгыг эх хэл, хууль эрх зүйн мэдлэг, цахим ур чадварыг үнэлэх агуулгатай байхаар төлөвлөсөн. Дээрх агуулгаар даалгавар боловсруулах багийг томилж бюпринтийн төлөвлөлтөд эх хэл 40 хувь хууль эрх зүй 30 хувь, цахим ур чадвар 30 хувь байхаар төлөвлөж боловсруулалтыг хийсэн.

Удирдлагаас авах бичгийн шалгалтын агуулга нь эх хэл 31 хувь, эрх зүй 38 хувь, цахим ур чадвар 31 хувь байхаар бюпринтийн төлөвлөлтийг хийсэн. Дээрх 2 чиглэлээр сорил даалгавар боловсруулах баг, экспертийн багийг томилж сэдэв даалгавар боловсруулах, нууцлалыг ханган ажиллах гэрээг байгуулж ажилласан.

Суралцагчаас авах бичгийн шалгалтыг сонгосон чадамжийн хөтөлбөрийн хүрээнд онолын мэдлэг болон ур чадварын гэсэн 2 хэсэгтэйгээр даалгавар боловсруулсан. Онолын мэдлэгийг сонгох хэлбэрийн даалгавартай байхаар төлөвлөж боловсруулсан бол ур чадварын даалгавар нь чадамжийн хөтөлбөр дэх үнэлгээний шалгуурт баримжаалан боловсруулагдсан.

Чанарын үнэлгээний арга хэрэгсэл боловсруулах

МБТБСБ-ын чанарын үнэлгээний асуулга судалгаанд суралцагч, багш, удирдлага, ажил олгогч, эцэг эх, тухайн сургуулийн төгсөгчийг хамруулахаар тооцож асуулгыг боловсруулсан. Дээрх 6 чиглэл тус бүрээр 2-оос 3 хүний бүрэлдхүүнтэй баг томилогдон боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн. Ингэхдээ асуулгын агуулгыг нарийвчлан тодорхойлж, асуулгаар тодруулах чиглэлийг тохирсон ба асуулгын дараах статистик үр дүнд фактор анализ хийхэд найдвартай байхад анхаарч ажиллах чиглэлийг өгсөн болно.

Чанарын үнэлгээний мэдээлэл цуглуулах арга хэрэгслийн нэг болох фокус ярилцлагыг суралцагч, багш, удирдлага, ажил олгогч, төгсөгчтэй хийхээр оролцогчдыг тодорхойлсон. Фокус ярилцлагыг боловсруулахдаа нэг чиглэлийн фокус ярилцлагыг 2 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллах ба ярилцлагын агуулга чиглэлийг мөн тодорхойлж, ярилцагчаас өгүүлж болох хариултын хувилбаруудыг аль болох бүрэн дүүрэн тодорхойлох, тэдгээрийг үнэлгээний мэдээлэл болгон кодлох зэргийг тооцож ажиллах чиглэл өгч ажиллав.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний хүрээнд хичээл ажиглалтыг онолын болон дадлагын хичээл дээр хийхээр төлөвлөлтөд тусгасны дагуу хичээл ажиглалтын хуудас боловсруулах багууд тус бүр 2 хүний бүрэлдхүүнтэй ажилласан. Ажиглалтын хуудсыг сайжруулах, нягтлах ажлыг төлөвлөгөөт хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Хяналт, үнэлгээний хуудсаар мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагаас статистик мэдээлэл, тусгай зөвшөөрөл, сургалтын бааз, дотуур байрны орчин, хөтөлбөр, төлөвлөлтийн талаарх мэдээллүүдийг авахаар төлөвлөн ажилласан.

- 1.3 Түүврийн хамрах хүрээ, хэмжээг тодорхойлох үйл ажиллагааны хүрээнд мэдээллийн сан дахь тоон мэдээлэлд тулгуурлан судалгааны олонлог, түүврийн хамрах хүрээ, хэмжээг тодорхойлох ажлыг удирдамж, арга зүйд нийцүүлэн зохион байгууллаа.

Түүврийн эх олонлогийг Улаанбаатар хотын 8 дүүргийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй 15 сургалтын байгууллагын статистикийн суурь мэдээлэлд үндэслэн тогтоосон.

Чанарын үнэлгээний судалгаанд хамрагдах суралцагчийн түүврийг энгийн санамсаргүй түүврийн аргад үндэслэсэн боловч сургалтын байгууллагаас хамруулах төлөөллийг тэнцүү магадлалтайгаар сонгох тохиолдолд хамгийн бага байх түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцож тодорхойлсон. Үүнд:

$$n = \frac{z^2 p(1-p)}{e^2} deff (1)$$

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудаас 15 сургуулийг сонгон авч тэдний ирүүлсэн статистик мэдээлэлд үндэслэн (1) томъёог ашиглан тооцоолж түүврийг хийсэн. Түүврийн томъёог ашиглан хийсэн түүвэрт дараах тооны багш, суралцагч, удирдах ажилтнууд сонгогдсон.



Түүврийн хүрэлцээтэй байдал /КМО/-ыг шинжилсэн үр дүнгээс харвал 0.8-аас дээш тоон утгатай байгаа нь хүлээн зөвшөөрөгдөх утга хангалттай түвшинд байгааг илэрхийлж байна. Мөн энэ удаагийн цуглуулсан үнэлгээний асуулга судалгаанд фактор шинжилгээ хийхэд ч түүврийн хүрэлцээтэй байдлын утга мөн адил 0.841-дээш хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байна.

Хүснэгт . Түүврийн хүрэлцээтэй байдлыг шинжилсэн үр дүн

KMO and Bartlett's Test		Удирдлага	Багш	Суралцагч	Эцэг эх, асран хамгаалагч	Төгсөгч	Ажил олгогч
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		0.899	0.930	0.976	0.844	0.821	0.88
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	1792.80	8534.62	44671.71	2012.038	951.70	1634.22
	df	325	946	465	231	120	105
	Sig.	0	0	0	0	0	0

1.4 Шалгалтын материал хэвлэх, ууталж савлах үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээл дээр сүүлийн 2-3 жил эрэлттэй байгаа мэргэжлийн хүрээнд 8 мэргэжлийн хөтөлбөрийг сонгон онолын мэдлэг болон ур чадварын гэсэн 2 хэсэгтэйгээр даалгавар боловсруулсан. Онолын мэдлэгийг сонгох хэлбэрийн даалгавартай байхаар боловсруулсан бөгөөд цаасан суурьтай байхаар тооцож бичгийн шалгалтын материалыг хэвлэх, уутлах ажлыг зохион байгуулсан. Үүнийг дараах зураглалын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Зураг бичгийн шалгалтын материал хэвлэх, ууталж савлах үйл ажиллагааны дараалал



Дээрх зураглалын дагуу бичгийн шалгалтын материалыг 3 чилэлээр хэвлэсэн байна.

№	Бичгийн шалгалтын дэвтрийн төрөл	Хэвлэсэн тоо ширхэг
1	Суралцагч	885
2	Багш	75
3	Удирдах ажилтан	30
4	Хариултын хуудас	1000

1.5 Сургалт зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд сургалтын байгууллагуудад мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах

талаар болон үнэлгээний арга хэрэгсэл боловсруулах, үнэлгээг сургалтын байгууллага дээр зохин байгуулах талаар сургалт мэдээллийг нийтдээ 5 удаа зохион байгууллаа. Тус сургалтад давхардсан тоогоор

2. Чанарын үнэлгээг зохион байгуулах

Зохион байгуулах комисс. МБТБСБ-ын чанарын үнэлгээг БҮТ-өөс томилогдсон 60 комиссын гишүүд НБГ-тай хамтран сонгогдсон сургуулиуд дээр зохион байгууллаа. Тухайн сургалтын байгууллага нь энэ удаагийн чанарын үнэлгээнд хамрагдах мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа эсэхтэй холбоотойгоор тухайн сургууль дээр бичгийн болон ур чадварын шалгалттай эсэхээс хамааран 1-2 хүний бүрэлдэхүүнтэй байсан болно.

Шалгалт судалгааны хуваарь: Бичгийн шалгалтыг Улаанбаатарын цагаар нэгэн зэрэг дараах хуваариар зохион байгууллаа.

№	Үйл ажиллагаа	Сар, өдөр	Эхлэх цаг
1	Суралцагчдын бичгийн шалгалт	2023.03.28	9:00
2	Удирдлага болон багшийн бичгийн шалгалт, онлайн асуулга	2023.03.28	14:00
3	Суралцагчдын ур чадварын үнэлгээ	2023.03.29	10:00
4	Чанарын үнэлгээний арга хэрэгслээр мэдээлэл цуглуулах	2023.03.27-30	


Үнэлгээний мэдээлэл цуглуулах үйл явц. Энэ удаагийн МБТБСБ-ын чанарын үнэлгээг цахим технологид суурилж үнэлгээний мэдээлэл цуглуулахыг зорисон бөгөөд бичгийн шалгалтыг хөдөө орон нутагт цаасан суурьтай авч үр дүнг хариултын хуудасд будуулсан бол нийслэлийн хувьд таблетэд суурилан шалгалтыг авч явууллаа. Мөн суралцагчийн, багшийн, удирдах ажилтны, эцэг эхийн, ажил олгогчийн, төгсөгчийн асуулга судалгаа, фокус ярилцлага, дадлагын хичээл ажиглалт, ур чадварын шалгалтын үр дүнгүүдийг Боловсролын үнэлгээний төвийн asuulqa.eec.mn портал сайтад шивүүлж үнэлгээний мэдээллийг бүрдүүлж авлаа.

БҮТ-өөс томилогдсон комиссоос гадна бичгийн шалгалттай сургуулиуд дээр үнэлгээний ажилтантай гэрээлж ур чадварын шалгалт болон хичээл ажиглалтыг хөтлөн явуулсан болно. Тухайн сургууль дээр ажиллах комисс болон үнэлгээний ажилтны ажил үүргийг дараах байдлаар хувиарласан болно.

№	Оролцогч	Үнэлгээний хэлбэрүүд						
		Мэргэжлийн хичээлийн шалгалт		Асуулга судалгаа	Фокус ярилцлага	Хичээл ажиглалт		Хяналт үнэлгээний хуудас
		Бичгийн шалгалт	Чадамжийн шалгалт			Онолын хичээл	Дадлагын хичээл	
1	Суралцагч	Комисс	Үнэлгээний ажилтан	Комисс	Комисс			
2	Багш	Комисс		Комисс	Комисс			
3	Удирдлага	Комисс		Комисс	Комисс			
4	Ажил олгогч			Комисс	Комисс			
5	Төгсөгч			Комисс	Комисс			
6	Эцэг эх			Комисс				
7	Сургалтын байгууллага					Үнэлгээний ажилтан	Үнэлгээний ажилтан	Комисс

3. Үр дүнг боловсруулах үйл ажиллагааг дараах зураглалын дагуу зохион байгууллаа. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын чанарын судалгаа, үнэлгээний үр дүнг цуглуулах, нэгтгэх, хэлбэржүүлэх түүнийг боловсруулах үйл ажиллагааг дараах зураглал /зураг /-ын дагуу зохион байгуулж, мэдээллийн сан бүрдүүлнэ.


Зураг 1. Өгөгдөл, мэдээлэл цуглуулах, боловсруулах менежментийн зураглал



Зураглалын дагуу мэдээлэл цуглуулснаар нийтдээ давхардсан тоогоор мэдээлэл цуглуулж нэгтгэх, хэлбэржүүлэх, боловсруулалт хийх BI tableau системд байршуулсан.

4. Тайлан боловсруулах үйл ажиллагааг дараах байдлаар хийхээр бэлтгэл ханган ажиллаж байна.


Зураг . Дэлгэрэнгүй тайлан, зөвлөмж боловсруулах үйл ажиллагааны дараалал



1.4 Судалгааны арга зүй, аргачлал

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээг тухайн байгууллагын үйл ажиллагааны *Оролт-Үйл явц-Гаралт*ын түвшин тус бүрд дараах ерөнхий чиглэлээр нарийвчилсан үзүүлэлт, нотлох баримт цуглуулах арга хэрэгслийг боловсруулан үнэлгээг зохион байгууллаа.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээний ерөнхий чиглэл



Чанарын үнэлгээний ерөнхий чиглэлд тулгуурлан судалгаа нь:

- Бичгийн шалгалт
- Асуулга судалгаа
- Хичээл ажиглалт
- Фокус бүлгийн ярилцлага
- Орчны үнэлгээ
- Сэтгэл ханамжийн судалгаанаас бүрдэнэ.

Бичгийн шалгалт нь багш, суралцагч, удирдах ажилтан гэсэн 3 чиглэлээр боловсруулан шалгалтын дээрээр буюу цаасан суурьтай зохион байгуулагдсан.

Асуулга, ажиглалтын хуудас болон фокус бүлгийн ярилцлагыг дараах байдлаар боловсрууллаа. Үүнд:

- ✦ Сургуулийн удирдлагын асуулга
- ✦ Багшийн асуулга
- ✦ Суралцагчийн асуулга
- ✦ Эцэг, эх, асран хамгаалагчийн асуулга
- ✦ Орчны стандартын хэрэгжилтийг үнэлэх хуудас

- ✦ Онолын болон дадлагын хичээл ажиглалтын хуудас
- ✦ Төгсөгч болон ажил олгогч нартай хийх ярилцлага
- ✦ Төгсөгч болон ажил олгогчоос авах асуулга гэсэн чиглэлээр тс бүр үнэлгээний хэрэгсэл боловсруулан үнэлгээг зохион байгуулсан.

Чанарын үнэлгээний арга зүй, аргачлалыг тодорхойлох зорилгоор 2 удаагийн хэлэлцүүлэг, 1 удаагийн сургалт, 2 удаагийн боловсруулах түвшинд семинар зохион байгуулсан.

Үнэлгээний арга хэрэгслийн найдвартай байдал (Кронбах альфа коэффициент)-ыг шинжилж үзсэн үр дүнг дараах хүснэгтээр нэгтгэн харууллаа.

Хүснэгт . Бичгийн шалгалтын найдвартай байдал

Шалгалтын төрөл	Найдвартай байдлын тоон утга
Суралцагчийн чадамжийн үнэлгээ	0.603
Багшийн чадамжийн үнэлгээ	0.802
Удирдлагын чадамжийн үнэлгээ	0.778

Хүснэгт . Асуулга судалгааны найдвартай байдал


Үнэлгээний арга хэрэгсэл	Найдвартай байдлын тоон утга
Суралцагчийн асуулга	0.940
Багшийн асуулга	0.950
Удирдлагын асуулга	0.933
Төгсөгчдийн асуулга	0.859
Эцэг, эх, асран хамгаалагчдын асуулга	0.855
Ажил олгогчийн асуулга	0.880

Дээрх 2 хүснэгтээс харахад найдвартай байдлын тоон утга 0.6-аас дээш байгаа нь судалгаанд боловсруулан ашигласан арга хэрэгсэл зорилгоо хангаж чадахуйц болсныг илэрхийлж байна.

ХОЁР. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ҮР ДҮН

2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдаас авсан шалгалтын ерөнхий үр дүн

Суралцагчдаас авсан бичгийн шалгалтад 15 сургуулийн 885 суралцагч хамрагдсан бөгөөд гүйцэтгэлийн дундаж **67.32** хувьтай шалгагдсан байна.



Судалгааны бичгийн шалгалтад хамрагдсан нийт суралцагчдын 35.7 хувь нь эмэгтэй, 64.3 хувь нь эрэгтэй суралцагчид байна. Тэдний сурлагын амжилтыг харьцуулсан мэдээллийг дараах графикаар харууллаа.

Сургалтын байгууллагын статусаар нь авч үзвэл мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс 175 суралцагч, политехникийн коллежоос 710 суралцагч судалгаанд хамрагдсан байна. Тэдгээрийн үр дүнг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Хүснэгт . Байгууллагын ангилалаар харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

№	Байгууллагын ангилал/статус	Шалгуулагчдын эзлэх хувь	Улсын дундаж	Хүйсээр	
				эрэгтэй	эмэгтэй
1	МСҮТ	19.8	65.5	64.2	68.8
2	ПТК	80.2	67.8	66.8	69.4

Байгууллагын статусаар харьцуулсан үр дүнгээс харахад мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын үр дүн 65.5 хувьтай, политехникийн коллежид суралцаж буй суралцагчид 67.8 хувьтай байна. Мөн хүйсээр харьцуулсан дүнгээс харахад эмэгтэй суралцагчид эрэгтэй суралцагчдаас 2,6-4,6 хувиар дээгүүр үзүүлэлттэй шалгагдсан байна.

Суралцагчдаас авсан чанарын үнэлгээний бичгийн шалгалтын үр дүнг сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр дэлгэрүүлэн шинжилж үзлээ. Үр дүнгээс харахад төрийн өмчийн болон төрийн бус өмчийн сургуулийн суралцагчдын хувьд гүйцэтгэлийн зөрүү маш бага байгаа боловч хүйсээр харьцуулсан үр дүнгээс харахад өгсөн даалгаврыг эмэгтэй суралцагчид эрэгтэй суралцагчдаас 2.3-3.8 хувиар дээгүүр гүйцэтгэсэн байгааг хүснэгт дэх дэлгэрэнгүй мэдээллээс харж болно.

Хүснэгт . Сургалтын байгууллагын өмчийн хэлбэр болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

Сургуулийн өмчийн хэлбэр	Улсын дундаж	Хүйсээр	
		эрэгтэй	эмэгтэй
Төрийн өмчийн	67.5	66.0	69.8
Төрийн бус өмчийн	67.1	66.4	68.7

Суралцагчдаас авсан бичгийн шалгалт нь онолын болон ур чадварын гэсэн 2 төрлөөр зохион байгуулагдсан бөгөөд онолын шалгалт нь сонгох хэлбэрийн 24 тест даалгавртайгаар, ур чадварын даалгаврууд нь чадамжийн нэгж дэх эзэмшвэл зохих цогц чадамжийг үнэлэхээр боловсруулагдсан байна. Шалгалтын төрлөөр улсын дундаж болон хүйсээр харьцуулсан үр дүнг доор хүснэгтэд нэгтгэсэн байна.

Хүснэгт . Шалгалтын төрлөөр болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

Шалгалтын төрөл	Улсын дундаж	Хүйсээр	
		эрэгтэй	эмэгтэй
Онолын шалгалт	44.7	43.1	47.5
Ур чадварын шалгалт	90.0	89.3	91.1

Улсын хэмжээний үр дүнг харьцуулахад суралцагчид онолын мэдлэг, чадварыг шалгасан даалгавруудыг сул гүйцэтгэсэн бол ур чадварын шалгалтыг 90 хувьтай гүйцэтгэсэн байна. Мөн хүйсээр харьцуулсан үр дүнгээр эмэгтэй суралцагчид онолын болон ур чадварын шалгалтыг эрэгтэй суралцагчдаас 1.8-4.4 хувийн зөрүүтэйгээр гүйцэтгэсэн байна.

Сургалтын байгууллагын нэр	Сургуулийн дундаж	Шалгалтын төрлөөр, гүйцэтгэлийн хувиар	
		Онол	Ур чадвар
Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж	71.4	55.5	87.4
Барилгын Бүтээцийн Үйлдвэрлэл МСҮТ	70.6	44.4	96.7
Их Засаг МСҮТ	70.0	42.5	97.6
Барилга, Технологийн Политехник коллеж	69.3	44.3	94.4
Хүнс, Технологийн Политехник Коллеж	69.2	44.6	93.9
Шинэ иргэншил Политехник коллеж	68.7	44.0	93.4
Универсал Политехник коллеж	68.0	43.6	92.4
Монгол-Солонгосын Политехник Коллеж	67.9	43.1	92.7
Налайх дүүрэг дэх Политехник Коллеж	67.1	40.9	93.3
Техник технологийн Политехник коллеж	66.9	44.9	89.0
ШУТИС-МТС-ийн дэргэдэх МСҮТ	66.9	41.9	91.9
Барилгын политехник коллеж	63.3	47.5	79.2
Донбоско МСҮТ	61.9	36.9	87.0
Хангай МСҮТ	60.3	38.0	82.5
Гэрэлт-Ирээдүй МСҮТ	52.1	23.0	81.3

Сургууль тус бүрийг харьцуулсан үр дүнгээс харахад сургуулийн ерөнхий дундаж гүйцэтгэлээрээ ҮУПК -ийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж 71.4 хувийн үзүүлэлттэй байгаа бол Гэрэл-Ирээдүй МСҮТ-ийн суралцагчдын гүйцэтгэл 52.1 хувийн үзүүлэлттэй шалгагдсан байна. Сургуулийн ерөнхий гүйцэтгэлийг шалгалтын төрлөөр харьцуулсан үр дүнгээс харахад онолын шалгалтаар ҮУПК 55.5%-ийн үзүүлэлттэй байгаа бол ур чадварын үнэлгээгээр Их Засаг МСҮТ 97.6%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Онолын даалгавруудыг төлөвлөлт хийх болон боловсруулахдаа Блумын таксаномийн танин мэдэхүйн 4 түвшинд харгалзуулан сонгогдсон мэргэжлийн хөтөлбөр тус бүрээр 24 даалгавртай нийт 50 онооны сорилын материалыг боловсруулж бэлтгэсэн.

Танин мэдэхүйн түвшин тус бүрд харгалзах даалгаврын эзлэх хувийг ойролцоогоор:

- Мэдлэг, ойлголтын түвшний даалгавар – 25%
- Чадварын түвшний даалгавар – 29%
- Хэрэглээний түвшний даалгавар – 29%
- Үнэлэх түвшний даалгаврын эзлэх хувь – 17% орчим хувьтай байхаар тооцож боловсруулсан.

Энэхүү танин мэдэхүйн түвшин тус бүрд харгалзах даалгаврын гүйцэтгэлийг авч үзэхэд практиктай холбосон буюу хэрэглээний даалгаврын гүйцэтгэл 48.5 хувьтай байгаа бол үнэлэх, чадвар шалгасан даалгавруудын гүйцэтгэл 41.6-42.4 хувьтай байна.

Хүснэгт . Танин мэдэхүйн түвшин болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар /онолын шалгалтаар/


Танин мэдэхүйн түвшин	Улсын дундаж	Хүйсээр	
		эрэгтэй	эмэгтэй
Мэдлэг, ойлголт	47.0	46.7	47.6
Чадвар	42.4	39.0	48.6
Хэрэглээ	48.5	47.5	50.4
Үнэлэх	41.6	39.8	44.5

Танин мэдэхүйн түвшний даалгавруудын гүйцэтгэлийг хүйсээр харьцуулсан дүнгээс харахад эрэгтэй, эмэгтэй суралцагчдын мэдлэг, ойлголтын түвшний даалгаврын гүйцэтгэлийн хувь ойролцоо байгаа бол бусад түвшний даалгавруудын хувьд эмэгтэй суралцагчдын гүйцэтгэл эрэгтэй суралцагчид болон улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Хүснэгт . Ур чадварын шалгалт болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар


Шалгалтын төрөл	Улсын дундаж	Хүйсээр	
		эрэгтэй	эмэгтэй
Автомашинь засварчин	96.7	97.1	96.7
Сантехникч	98.8	88.2	98.8
Барилгын цахилгаанчин	85.5	83.5	85.5
Гагнуурчин	87.5	85.5	87.5
Засал чимэглэл	88.5	89.3	88.5
Оёдол	91.1	*	91.1
Тогооч	91.3	88.9	91.3
Үсчин	91.4	90.0	91.4

Чадамжийн хөтөлбөрүүдийг хүйсээр харьцуулахаас гадна шалгалтын төрлөөр харьцуулан дүн шинжилгээ хийх боломжтой юм. Доорх графикаас



Бичгийн шалгалтад хамрагдсан 885 суралцагчийн суралцаж буй сургуулийн байршил буюу дүүргээр мэдээллийг нэгтгэн харууллаа.

График . Дүүрэг тус бүрээр харьцуулсан үр дүн



Графикаас харахад Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд улсын дунджаас 4.1-0.6 хувийн дээгүүр үзүүлэлттэй байгаа бол Баянзүрх дүүргийн хувьд улсын дундажтай ойролцоо үр дүн үзүүлсэн байна. Харин Налайх, Баянгол, Багануур дүүргийн хувьд улсын дунджаас 0.1-15.2 хувиар доогуур үзүүлэлттэй шалгагдсан байна.

Мөн дүүрэг тус бүрийн улсын дунжийг хүйсээр задалж харьцуулсан үр дүнг доорх хүснэгтэд нэгтгэн харуулсан байна.

Дүүргийн нэр	Дүүргийн дундаж	Хүйсээр	
		эрэгтэй	эмэгтэй
Сүхбаатар	71.4	75.0	70.3
Сонгинохайрхан	70.0	69.6	70.1
Чингэлтэй	68.7	69.2	67.7
Хан-Уул	67.9	67.4	69.0
Баянзүрх	67.2	66.8	67.7
Налайх	67.1	65.1	69.3
Баянгол	66.2	65.6	68.9
Багануур	52.1	52.1	*

Хүснэгт дэх мэдээллээс харахад Сүхбаатар дүүргийн сургалтын байгууллагад суралцдаг сурагчдын бичгийн шалгалтын үр дүн бусдаас илүү шалгагдсан бол Багануур дүүргийн сургалтын байгууллагад суралцдаг сурагчдын үнэлгээний үр дүн 52.1 хувьтай гарсан байна.

2.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах ажилтнаас авсан шалгалтын ерөнхий үр дүн

Энэ удаагийн чанарын үнэлгээний судалгаанд удирдах ажилтны чадамжийн үнэлгээг үндэсний болон салбарын бодлого, эрх зүйн шинэчлэл хийх гэж буйтай уялдуулан

монгол хэл бичиг, хууль эрх зүйн мэдлэг, ойлголт, цахим ур чадвар гэсэн 3 чиглэлээр сонгох хэлбэрийн 58 тест даалгавар боловсруулан үнэлгээ хийсэн.

Хүснэгт . Агуулгын хүрээ, даалгаврын эзлэх хувь

№	Ерөнхий агуулга	Эзлэх хувь
1	Монгол хэл бичиг	31
2	Эрх зүйн мэдлэг	38
3	Цахим ур чадвар	31

Дээрх 3 агуулгын хүрээнд удирдах ажилтнаас авсан шалгалтын үр дүн 67.40 хувьтай гарсан байгаагаас төрийн өмчийн сургуулиудын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн дундаж 76.5%-тай, төрийн бус өмчийн сургуулиудын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн дундаж 62.6%-тай байна.


Мөн шалгалтын үр дүн агуулгын 3 чиглэлээр авч үзвэл хууль эрх зүйн мэдлэгийг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 71.79%-тай, монгол хэл бичгийн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 68.97%-тай, цахим ур чадварын үнэлгээний даалгавруудын гүйцэтгэл 61.44%-тай үнэлэгдсэн байна.

Удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээний үр дүн байгууллагын ангилалаас хэрхэн хамаарч байгааг судалсан дүнгээр МСҮТ-ийн удирдах ажилтнуудын үнэлгээ 61.43%-тай, ПТК-ийн удирдах ажилтнуудын үнэлгээ 71.04%-тай гарсан байна.

Мөн магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын удирдах ажилтнуудын амжилт 75.76%-тай байгаа бол магадлан итгэмжлэгдээгүй сургалтын байгууллагын Удирдах ажилтнуудын гүйцэтгэл 66.06%-тай гарсан байна.

Судалгаанд хамрагдсан удирдах ажилтнуудын хүйсээс хамаарсан судалгааг хийж харьцуулахад 69.7% нь эмэгтэй, 30.3% нь эрэгтэй албан хаагчид хамрагдсан байна. Удирдах ажилтнуудын хүйсээс хамаарсан чадамжийн үнэлгээний үр дүнг авч үзвэл эмэгтэй албан хаагчдын гүйцэтгэлийн дундаж 61.7%-тай, эрэгтэй албан хаагчдын гүйцэтгэлийн дундаж 53.6%-тай байна.

Үнэлгээнд хамрагдсан сургуулиудын удирдах ажилтнуудыг ажилласан жилээр нь авч үзвэл 182% нь эхний жилдээ, 42.4% нь 1-5 жил, 27.3% нь 6-10 жил, 3% нь 16-20 жил,




9.1% нь 21-с дээш жил ажилласан мэдээлэл бүртгэгдсэн байна. Тэдний чадамжийн үнэлгээний үр дүнг харьцуулан харууллаа.

Графикаас харахад 16-20 жил ажиллаж буй удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээ 74.2%-тай байгаа бол 1-5 жил ажиллаж байгаа удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээ 53.4%-тай байна.

Удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээний үр дүнг харьяалагдах дүүрэг тус бүрээр дэлгэрэнгүй үзүүлэлтийг гарган харьцуулахад Налайх дүүргийн багш нарын чадамжийн үнэлгээ 79.5 хувьтай үнэлэгдсэн бол Сонгинохайрхан дүүргийн удирдах ажилтнуудын чадамж 51.5%-ийн үзүүлэлтэй үнэлэгдсэн байна.

График . Удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээний үр дүн, дүүргээр



Дүүргийн хэмжээний үр дүнг нарийвчлан сургуулийн дундаж болон агуулга тус бүрээр үр дүнг дэлгэрүүлэн дараах хүснэгтээр нэгтгэн харууллаа. Үүнд:

Сургалтын байгууллагын нэр	Сургуулийн дундаж	Монгол хэл бичиг	Хууль эрх зүй	Цахим ур чадвар
Монгол-Солонгосын Политехник Коллеж	87,9	93.2	88.6	81.8
Барилга, Технологийн Политехник коллеж	75,0	84.1	81.8	59.1
Техник технологийн Политехник коллеж	68,9	79.5	68.2	59.1
Налайх дүүрэг дэх Политехник Коллеж	79,5	79.5	86.4	72.7
Хангай МСҮТ	65,9	75.0	59.1	63.6
ШУТИС-МТС-ийн дэргэдэх МСҮТ	67,4	72.7	70.5	59.1
Барилгын политехник коллеж	72,0	70.5	86.4	59.1
Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж	75,8	68.2	86.4	72.7
Барилгын Бүтээцийн Үйлдвэрлэл МСҮТ	69,7	63.6	72.7	72.7
Универсал Политехник коллеж	50,8	59.1	45.5	47.7
Шинэ иргэншил Политехник коллеж	65,9	59.1	70.5	68.2
Их Засаг МСҮТ	51,5	56.8	59.1	38.6
Гэрэлт-Ирээдүй МСҮТ	58,6	56.8	68.2	47.7
Хүнс, Технологийн Политехник Коллеж	63,6	54.5	70.5	65.9
Донбоско МСҮТ	51,5	54.5	54.5	45.5

Хүснэгт дэх мэдээллээс сургууль тус бүрээс хамрагдсан удирдах ажилтнуудын амжилтыг агуулгаар харьцуулан үзэхэд:

- Сургуулийн ерөнхий гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтээр Монгол-Солонгосын ПК 87.9%-тай үнэлэгдсэн бол Универсал ПК-ийн гүйцэтгэлийн дундаж 50.8%-ийн үр дүнтэй гарсан байна.
- Монгол хэл бичгийн шалгалтын үр дүнгээр Монгол-Солонгосын ПК-ийн удирдах ажилтнууд 93.2%-ийн амжилтаар бусад сургуулиас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Донбоско МСҮТ-ийн удирдах ажилтнуудын гүйцэтгэл 54.5%-ийн үр дүнтэй үнэлэгдсэн байна.
- Хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгаврын гүйцэтгэлээр Монгол-Солонгосын ПК-ийн удирдлагууд 88.6%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн бол Универсал ПК-ийн удирдлагууд 45.45%-тай үнэлэгдсэн байна.
- Цахим ур чадварыг шалгасан даалгавруудын гүйцэтгэлээр Монгол-Солонгосын ПК-ийн удирдлагууд 81.8%-тай үнэлэгдсэн бол Их Засаг МСҮТ-ийн багш нар 38.6%-тай байна.

2.3 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нараас авсан шалгалтын ерөнхий үр дүн

Багш нараас авах чадамжийн үнэлгээг үндэсний болон салбарын бодлого, эрх зүйн шинэчлэл хийх гэж буйтай уялдуулан монгол хэл бичиг, хууль эрх зүйн мэдлэг, ойлголт, цахим ур чадвар гэсэн 3 чиглэлээр сонгох хэлбэрийн 58 тест даалгавар боловсруулан үнэлгээ хийсэн.

Хүснэгт . Агуулгын хүрээ, даалгаврын эзлэх хувь

№	Ерөнхий агуулга	Эзлэх хувь
1	Монгол хэл бичиг	40
2	Эрх зүйн мэдлэг	30
3	Цахим ур чадвар	30

Дээрх 3 агуулгын хүрээнд удирдах ажилтнаас авсан шалгалтын үр дүн 62.50 хувьтай гарсан байгаагаас төрийн өмчийн сургуулиудын багш нарын гүйцэтгэлийн дундаж 70.4%-тай, төрийн бус өмчийн сургуулиудын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн дундаж 58.3%-тай байна.

Мөн шалгалтын үр дүн агуулгын 3 чиглэлээр авч үзвэл хууль эрх зүйн мэдлэгийг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 61.8%-тай, монгол хэл бичгийн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 60.7%-тай, цахим ур чадварын үнэлгээний даалгавруудын гүйцэтгэл 65.4%-тай үнэлэгдсэн байна.


Багшийн чадамжийн үнэлгээний үр дүн байгууллагын ангилалаас хэрхэн хамаарч байгааг судалсан дүнгээр МСҮТ-ийн багш нарын үнэлгээ 55.1%-тай, ПТК-ийн багш нарын үнэлгээ 67.8%-тай гарсан байна.

Мөн магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын багш нарын амжилт 67.5%-тай байгаа бол магадлан итгэмжлэгдээгүй сургалтын байгууллагын багш нарын гүйцэтгэл 61.7%-тай гарсан байна.

Багш нарыг боловсролын түвшнээр нь харьцуулахад нийт багш нарын 47.3% нь магистр зэрэгтэй, 40.5 хувь нь бакалавр, 12.2 хувь нь дипломын боловсролтой хэмээн хариулсан байна. Тэдгээр багш нарын чадамжийн үнэлгээний үр дүнг нэгтгэн харууллаа.



Мөн судалгаанд хамрагдсан багш нарыг мэргэжлийн түвшнээр нь ангилж үзэхэд 2.7 хувь нь мастер багш, 70.3 хувь нь багш, 21.6 хувь нь ахлах багш, 5.4 хувь нь дадлагажигч багш зэрэгтэй байна. Тэдгээр багш нарын чадамжийн үнэлгээний үр дүнг харьцуулан судлахад:



Багшийн чадамжийн үнэлгээний үр дүнг харьяалагдах дүүрэг тус бүрээр дэлгэрэнгүй үзүүлэлтийг гаргах харьцуулахад Сүхбаатар дүүргийн багш нарын чадамжийн үнэлгээ 79.4 хувьтай үнэлэгдсэн бол Багануур, Чингэлтэй дүүргийн багш нарын чадамж 50%-ийн үзүүлэлтэй үнэлэгдсэн байна.

График . Багшийн чадамжийн үнэлгээний үр дүн, дүүргээр



Дүүргийн хэмжээний үр дүнг нарийвчлан сургуудийн дундаж болон агуулга тус бүрээр үр дүнг дэлгэрүүлэн дараах хүснэгтээр нэгтгэн харууллаа. Үүнд:

Сургалтын байгууллагын нэр	Сургуулийн дундаж	Монгол хэл бичиг	Хууль эрх зүй	Цахим ур чадвар
Барилгын политехник коллеж	78.5	76.4	76.7	82.7
Монгол-Солонгосын Политехник Коллеж	82.1	75.0	90.0	84.5
Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж	79.4	74.3	77.8	87.3
Барилга, Технологийн Политехник коллеж	73.5	67.9	73.3	80.9
ШУТИС-МТС-ийн дэргэдэх МСҮТ	46.5	64.3	43.3	26.4
Налайх дүүрэг дэх Политехник Коллеж	65.6	63.6	54.4	77.3
Их Засаг МСҮТ	61.2	62.1	56.7	63.6
Барилгын Бүтээцийн Үйлдвэрлэл МСҮТ	64.1	60.0	63.3	70.0
Хүнс, Технологийн Политехник Коллеж	52.9	58.6	46.7	50.9
Техник технологийн Политехник коллеж	65.3	55.0	67.8	76.4
Гэрэлт-Ирээдүй МСҮТ	50.0	52.1	56.7	41.8
Универсал Политехник коллеж	52.1	50.7	51.1	54.5
Донбоско МСҮТ	52.6	50.0	56.7	52.7
Хангай МСҮТ	56.2	48.6	50.0	70.9
Шинэ иргэншил Политехник коллеж	49.4	37.5	63.9	54.5

Хүснэгт дэх мэдээллээс сургууль тус бүрээс хамрагдсан багш нарын амжилтыг агуулгаар харьцуулан үзэхэд:

- Багш нарын чадамжийн үнэлгээний ер дүнг сургуулиар харьцуулсан дүнгээр Монгол-Солонгосын ПК-ийн гүйцэтгэлийн дундаж 82.1%-тай байгаа бол ШУТИС-МТС-ийн дэргэдэх МСҮТ-ийн ерөнхий гүйцэтгэлийн дундаж 46.5%-тай гарсан байна.

- Монгол хэл бичгийн шалгалтын үр дүнгээр Барилгын политехник коллежийн багш нар 76.4%-ийн амжилтаар бусад сургуулийн багш нараас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Шинэ иргэншил ПК-ийн багш нар 37.5%-ийн үр дүнтэй үнэлэгдсэн байна.
- Хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгаврын гүйцэтгэлээр Монгол-Солонгосын ПК-ийн багш нар 90%-ийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн бол ШУТИС-МТС-ийн дэргэдэх МСҮТ-ийн багш нар 43.3%-тай байна.
- Цахим ур чадварыг шалгасан даалгавруудын гүйцэтгэлээр Үйлдвэр Урлалын ПК-ийн багш нар 87.3%-тай үнэлэгдсэн бол ШУТИС-МТС-ийн дэргэдэх МСҮТ-ийн багш нар 26.4%-тай байна.

ГУРАВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээг зохион байгуулах болсон гол үндэслэл нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбараас боловсролын салбарт шилжин ирсэнтэй холбоотойгоор сургалтын байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, суурь үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлэх, үнэлгээний үр дүнд үндэслэн тайлан, зөвлөмж боловсруулж салбарын түвшинд цаашид авч хэрэгжүүлэх бодлого, баримтлах чиглэлийг боловруулах, түүний хэрэгжилтийг ханган ажиллах хэрэгцээ шаардлагатай холбоотой юм.

Мэргэжлийн боловсролын салбарт хийсэн чанарын үнэлгээг анх удаа зохион байгуулахдаа цогц байдлаар буюу орц, үйл явц, гарцын түвшинд, өөр хоорондын хамаарлыг судлах, дүн шинжилгээ хийхийг зорьсон билээ. Энэ хүрээнд гарцын түвшинд суралцагчийн чадамж, багшийн чадамж, удирдах ажилтны чадамж, төгсөгч болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлж дэлгэрэнгүй шинжилгээ хийх улмаар орц, үйл явцыг үнэлэхийг зорьсон болно.

Үнэлгээг зохион байгуулснаар бүх түвшиндөө судалгааны үр дүнг ашиглах, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх, түүнийг хэрэгжүүлэх, засан сайжруулах, нөөцийн хувиарлалтыг зөв оновтой хийх зэрэг боломжийг олгож байгаагаас гадна мэргэжлийн хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, багшлахуй, суралцахуйг сайжруулахад чухал дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэж байна.

Судалгааны үр дүнгээс дараах ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг гаргаж болохоор байна. Үүнд:

1. Улаанбаатар хотын 15 сургуулийг сонгон авч чанарын үнэлгээ зохион байгуулснаас 6 (40%) сургууль нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, 9 (60%) сургууль нь политехникийн коллеж гэсэн ангилалд хамаарч байна.
2. 15 сургуулийн хувьд чанарын үнэлгээнд 885 суралцагч, 75 багш, 30 удирдах ажилтан бичгийн шалгалт болон асуулга судалгаанд хамрагдсан байна.
3. Судалгаанд хамрагдсан 15 сургуулийн суралцагчдын бичгийн шалгалтын үнэлгээний ерөнхий дундаж 67.32 хувьтай гарснаас эмэгтэй суралцагчдын амжилт 69.3 хувьтай, эрэгтэй суралцагчдын амжилт 66.2 хувьтай гарсан байна.
4. Суралцагчдаас авсан бичгийн шалгалтын үр дүнг байршил, сургуулийн өмч, байгууллагын ангилал зэрэг үзүүлэлтүүдийг хүйсээр дэлгэрүүлэн шинжилгээ хийж

- үзэхэд судалгаанд хамрагдсан эмэгтэй суралцагчдын амжилт эрэгтэй суралцагчдынхаас дээгүүр байна.
5. Суралцагчдаас авсан онолын шалгалтын гүйцэтгэлийн дундаж 44.7 хувьтай, ур чадварын үнэлгээний гүйцэтгэлийн дундаж 90.0 хувьтай шалгагдсан байна. Онолын шалгалтын үр дүн доогуур үзүүлэлттэй байгаа нь танхимаар судлах цаг, чадамжийн хөтөлбөрийн агуулгын багтаамж, багшийн заах арга зүй, орчин зэргээс хамаарах магадлал өндөр тул цаашид үр дүнг дэлгэрүүлэн судлах шаардлагатайг харуулж байна.
 6. Ур чадварын шалгалтын үр дүн хэдийгээр өндөр гарсан боловч чадамжийн хөтөлбөр, чадамжийн нэгжийн агуулгаар дэлгэрүүлэн шинжилгээ хийх нь зүйтэй юм.
 7. Суралцагчдаас авсан бичгийн шалгалтын үр дүнг сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр ангилан харьцуулахад суралцагчдын гүйцэтгэлийн дундаж ойролцоо буюу 67.1-67.5 хувьтай гарсан байна.
 8. Танин мэдэхүйн түвшнээр суралцагчдын гүйцэтгэлийг харьцуулахад хэрэглээний даалгаврын гүйцэтгэл хамгийн өндөр буюу 48.5 хувьтай байгаа нь цаашид сургалтын үйл ажиллагааг онол, практиктай хослуулах хэрэгцээ шаардлага их байгааг харуулж байна.
 9. Мөн чадамжийн хөтөлбөрөөр суралцагчдын мэдлэг, ойлголтоос гадна задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, аливааг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах, тооцоо хийх зэрэг танин мэдэхүйн дээд эрэмбийн чадваруудыг хөгжүүлэхэд анхаарч хөтөлбөрийн боловсруулалт, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгцээ байгааг илэрхийлж байна.
 10. Танин мэдэхүйн түвшин түүнд харгалзах чадварын гүйцэтгэлийг сайжруулах шаардлага байгааг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан ЕБС-ийн чанарын үнэлгээний үр дүнгээс харж болно. Тухайлбал, тус судалгаанд МБС-ын 44 байгууллагын 3962 суралцагчаас авсан цогц чадамжийг илрүүлэх бичгийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж 27.79 хувьтай үнэлэгдсэн байгаагаас асуудал шийдвэрлэх чадварын гүйцэтгэл 21.59%, хамтран суралцах чадварыг үнэлсэн даалгавруудын гүйцэтгэл 57.23%, мэдээлэлтэй ажиллах, чадварын шалгасан даалгавруудын гүйцэтгэл 42.89%-тай гарсан байна. Дээрх цогц чадамжуудыг үнэлсэн үнэлгээний үр дүнд нэлээд анхаарал татахуйц үзүүлэлт байгаа нь асуудлыг олж харах чадвар 52.18%-тай, асуудлыг харьцуулж сонгох чадварын гүйцэтгэл 24.39%, баримт нотолгоо нэмэх чадварын гүйцэтгэл 11.25%, дүгнэлт гаргах чадвар 1.46%-тай үнэлэгдсэн явдал юм.
 11. Энэ удаагийн үнэлгээнд сонгон авсан 8 хөтөлбөрийн хүрээнд чадамжийн хөтөлбөр, чадамжийн нэгж болон үнэлгээний шалгуур, үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй шинжилгээ хийснээр тухайн байгууллагын хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид анхаарах агуулга, танин мэдэхүйн түвшин зэргийг тодорхойлсноор сургуулийн менежмент, багшийн тасралтгүй хөгжлийг хангах зөв оновчтой бодлогыг хэрэгжүүлэх боломж, нөөц бүрдэнэ. Тухайлбал; автомашины засварчин чадамжийн нэгжийг агуулгаар нь:
 - а. Авто машины бүтэц, зохион байгуулалтыг судлах
 - б. Авто машинд оношилгоо, техникийн үйлчилгээ хийх
 - с. Техникийн мэдээлэл ашиглах

- d. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах гэсэн 4 агуулга болгон задалснаас “d” буюу ХАБЭА-н шаардлагыг хангаж ажиллах агуулгын даалгавруудын гүйцэтгэл 34.2%-тай үнэлэгдсэн байна. Мөн техникийн мэдээлэл ашиглах мэдлэг, чадаврыг шалгасан даалгаврын гүйцэтгэл 36.7%-тай үнэлэгдсэн байгаа нь чанарын үнэлгээний цугуулсан мэдээлэлд дэлгэрэнгүй шинжилгээ хийж тайлан, зөвлөмжийг нарийвчлан боловсруулах шаардлага байгааг илэрхийлж байна.

---o0o---